

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Ш.ЭНХТӨР ТАНАА

2020.02.27 № 06/623
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1. Аудитын тайлан

2.1. Оршил

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирал Ш.Энхтөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, батлагдсан төсөв гүйцэтгэл, санхүүгийн болон эмийн программ, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 30-наас 2020 оны 2 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди -Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 79 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Монгол улсад эх, хүүхдэд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг чанарын өндөр түвшинд, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тав тухтай орчинд үзүүлж, дэлхийн жишигт хүрсэн үйлчилгээг эрхэмлэхэд оршино.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын хэмжээнд эх хүүхдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ үзүүлэх;
- Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг урт богино хугацааны мэргэшүүлэх сургалт;
- Бусад эрүүл мэндийн байгууллагуудад лавлагаа, тусламж үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль ;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албаны татварын тухай хууль;

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам, "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт", "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам",
- Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам",
- Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам",
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэх тухай",
- Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл",

Монгол Улсын Сангийн сайдын тушаал:

- Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгийг олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

1. 2019 ОНЫ УРИА: "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг бүрэн хангаж, эрсдэлгүй ажиллацгаая"

2019 оны уриаг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилго, зорилтыг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

1. Иргэдийн эрэлт хэрэгцээ, хүсэлтэд нийцэх шийдлийг эрэлхийлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи, инновацийг ашиглах замаар процесс үйл ажиллагаандаа өөрчлөлт хийх.
 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, эмнэлзүйн эрсдэлийг бууруулах.
 3. Шинэ дэвшилтэт технологийг бүрэн эзэмшиж, нутагшуулах.
 4. Нотолгоонд суурилсан интервенцийг нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлэх.
 5. Санхүүгийн удирдлагын үр дүн, ил тод байдлыг сайжруулах.
2. Манай хамт олон үйлчлүүлэгч төвтэй тусламж үзүүлж, эрүүл мэндийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчид болон тусламж үзүүлэгчдийн хоёр талын сэтгэл ханамжийн баталгааг хангахад гол анхаарлаа хандуулан ажилласан байна.
3. ЭХЭМҮТ нь “Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасаг”, “Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасаг”-т дэлхийн жишигтэй хөл нийлүүлэн ажиллаж, “ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны стандарт”-ыг нэвтрүүлсэн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив ХХК-ийн “Emerald” программ хангамж ашигладаг байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд 13 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 38,997,962.1 мянган төгрөгөөс тооцон 389,979.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон 1.0 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг ажил гүйлгээний тоо хэмжээ их болон эрсдэлийн түвшин “дунд” зэргээс хамаарч тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,066,240.7 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	6.9	6.9
Авлага	283,711.9	152,641.3	(131,070.6)
Урьдчилгаа			
Бараа материал	4,049,506.5	3,504,814.3	(544,692.1)
Үндсэн хөрөнгө	61,396,188.9	59,005,704.1	(2,390,484.8)
Нийт хөрөнгө	65,729,407.5	62,663,166.7	(3,066,240.7)
Өр төлбөр	7,584.0	8,700.8	1,116.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	65,721,823.4	62,654,465.8	(3,067,357.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	65,729,407.5	62,663,166.7	(3,066,240.7)

Байгууллагаас авах авлага буурсан байна. Авлагын дансны үлдэгдэл бүгд 152,641.3 мянган төгрөг, үүнээс 142,084.8 мянган төгрөгийн байгууллагаас авах, 10,556.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага бөгөөд барагдуулах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй байна. Байгууллагаас авах 101,910.0 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтээр буюу олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг жилийн эцэст улсын төсөвт татан төвлөрүүлсэн учир Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд бараа материал нийт 12,772,159.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 10,999.937.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1,772,221.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэгүй болон дотоод хөдөлгөөнөөр орлого болгон авсан байна. Мөн нийт 13,316,851.3 мянган төгрөгийн бараа материал хасагдсан ба үүний 10,721,917.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,255,747.3 мянган төгрөгийн бараа материалыг өмнөх жилийн аудитын зөвлөмжийн дагуу акталж (бараа материалыг зөв ангилж), 1,369,287.3 мянган төгрөгийн бараа материалыг дотоод хөдөлгөөнөөр зарлага болгосон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийснээс 1,958,172.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 325,745.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 1,428,299.9 мянган төгрөг, данс хоорондын шилжүүлгээр 326,980.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-1/3660 тогтоолоор 20,752.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн элэгдлийг 6,424,467.8 мянган төгрөгөөр байгуулсан нь үндсэн хөрөнгийн цэвэр дүн буурахад нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,297.9 мянган төгрөгийн түрээслэгч байгууллагуудын барьцаа хөрөнгө, Шинжлэх ухаан технологийн сангийн төслийн

санхүүжилтээр 2 жилийн гэрээтэй нийлүүлэх харшлын аппаратны 6,157.8 мянган төгрөг байна. Энэ нь нийт өр төлбөрийн 70.0 хувийг эзэлж байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлант онд 33,357,617.5 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 33,215,962.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.6 хувиар биелүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх тусламж, үйлчилгээний орлого 34,945.2 мянган төгрөгөөр, ангиографийн аппарат 12 сард эвдэрснээс хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийн төлөвлөгөөт мэс засал хийгдээгүй, тасарсан, мөн эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн хагалгааны өрөөнүүд иж бүрэн засварт орсноор төлөвлөгөөт мэс заслууд хийгдээгүйтэй холбоотой байна. Төлбөртэй тусламж үйлчилгээ хийгдэхгүй байгаа учраас төлөвлөгөө 60,927.1 мянган төгрөгөөр тасарсан. ЭМЯ-наас төлбөртэй тусламж үйлчилгээний журам, жагсаалтыг шинэчлэхээр хүлээгдэж байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрт зориулан 33,357,617.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 33,224,357.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бөгөөд 141,661.5 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гаргасан байна.

Нийт зардлын 23,041,226.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,626,611.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 689,779.6 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийн хүрээнд ШУТС-гаас 75,735.0 мянга, НЭМҮТ-өөс 10,000.0 мянга, тайлант жилийн давсан орлого 73,104.5 мянга, ЭМХТ-өөс 131,521.6 мянга, НҮБ-ийн хүүхдийн сангаас 144,616.0 мянга, ДЭМБ-аас 117,708.7 мянга, Олон улсын “Орбис” төслөөс 103,138.2 мянга, 2018 оны давсан орлогоос 207,330.3 мянга, нийт 863,154.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 746,003.5 мянган төгрөгийг төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулж, үлдэгдэл 117,151.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 398,631.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 121,254.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 246,800.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 30,577.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 246,800.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. “Мишээл-Од Аудит” ХХК-тай Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчлэлтийг хийлгэх 30 хоногийн хугацаатай гэрээг 2018 оны 12 дугаар сарын 18-нд байгуулж, 5,500.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 “Ерөнхий

нягтлан бодогч нь аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээнэ”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчил арилгах албан шаардлага өгөх,

2. Мэдээ мэдээлэл, ярилцлага сурталчилгааг түгээх зорилгоор 2 төрийн бус байгууллагатай 15,000.0 мянган төгрөг, 1 компанитай 10,000.0 мянган төгрөг, нийт 35,000.0 мянган төгрөгийн гэрээг шууд байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадална", Сангийн сайдын 2012 оны 194 дугаар тушаалаар батлагдсан "Тендерийн үнэлгээний заавар"-тай нийцэхгүй буюу үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчил арилгах албан шаардлага өгөх,

3.Компьютер томографын болон ангиографийн аппаратын 206,300.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээний ажилд тендер зарлаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлан тухай" 2013 оны 68 дугаар тогтоолтой нийцэхгүй буюу үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчил арилгах албан шаардлага өгөх,

Аудитаар илэрсэн 30,577.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эмийн тооцоо, хяналт, бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс (БҮТЭЗ)-ийн бүртгэлийг боловсронгуй болгох, эрүүл мэндийн салбарын хэмжээнд нэгдсэн бодлоготой болгох, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хэрэгжиж байгаа “Орбис”, “НҮБ-ийн хүүхдийн сан” төслүүдэд үйл ажиллагааны аудит хийх нь зүйтэй гэж үзлээ.

Тайлант онд төрийн албан хаагчид олгох илүү цагийн хөлсөнд 2,211.9 мянга, хүнд хортой нөхцөлийн нэмэгдэлд 953.0 мянга, үндсэн цалингийн шатлалын зөрүүнд 16,668.9 мянга, зэргийн нэмэгдэлд 2,470.5 мянга, урамшуулалт цалинд 3,592.6 мянга, сургалтын цалинд 1,257.8 мянган төгрөг нийт 27,154.7 мянган төгрөгийн нэмэгдлийг тэтгэвэр тогтоолгосны дараа хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа 15 их эмчид олгосон асуудлыг цаашид анхаарч дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 1,108 мэдээллийг хугацаанд нь “Шилэн данс”-ны цахим хуудсанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, цалингаас бусад 5.0 саяас дээш гүйлгээ, тендерийн худалдан авалт, гэрээ, орон тооны өөрчлөлт болон бусад мэдээ мэдээллийг заасан хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 31,483.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 12,156,912.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 11,357,222.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 277,377.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тооцсон 389,979.6 мянган төгрөгийн материаллаг байдлын дүнгээс бага тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

2. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Санхүүгийн “Эмиралд” программыг ашиглаж байгаа боловч, шинэчлэлт сайжруулалт хийгээгүй, санхүүгийн болон эмийн программ нь хоорондоо холбоогүй. Эмийн орлого, зарлагыг санхүүгийн болон эмийн программд тус тусад нь бүртгэж байна.
- 1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийг буруу хөтлөх, тайлан буруу илэрхийлэх, нягтлан бодогчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх,
- 1.3. Өгсөн зөвлөмж: Санхүүгийн програмын шинэчлэлт хийж, бараа материал (эм, эмийн хэрэгсэл) болон кассын тайлан зэргийг нэгтгэж гаргадаг болгох, НБББББ-ыг санхүүгийн программын шинэчлэлтэй уялдуулж шинэчилж, ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.-т “үнэн зөв байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах, Сангийн яамнаас зөвшөөрөгдсөн программыг хэрэглэх,
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: ЭХЭМҮТ-ийн санхүүгийн алба нь “Интерактив” ХХК-ийн “Emerald” санхүүгийн програмыг 2012 оноос одоог хүртэл ашиглаж байна. “Интерактив” ХХК-иас нэмэлт хөгжүүлэлт хийгдэхгүй, шинэчилсэн хувилбарыг худалдан авахыг санал болгож байна. Шинэ хувилбарыг худалдан авахад их хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай ба ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар “Цахим эрүүл мэнд” төсөл хэрэгжиж байна. Үүний дараа ДЭМБ нь 7 төрлийн програм хангамж нэвтрүүлэхээр болсон уг програмд санхүүгийн цогц програм нэвтрэх юм.

2. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Хүүхдийн эмчилгээг бүрүү хийсний улмаас 2019 онд нэр бүхий 1 иргэнд шүүхийн шийдвэрээр олгохоор болсон 30,581.6 мянган төгрөгийн эмчилгээний төлбөрийг эмийн зардлын төсвөөс олгосон байна.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5-т “Төсвийн шүүд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 16 дугаар зүйлийн 5.5-т “батлагдсан

төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчих, эмийн зардал хүрэлцэхгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5-т “*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэжүүлнэ:*”, 16 дугаар зүйлийн 5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,333,218,530.23	3,657,462,606.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	6,900.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	6,900.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	6,900.00
33	АВЛАГА	283,711,977.03	152,641,340.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,115,550.00	10,556,539.98
33300	Татаас, санхүүжилтийн авлага	207,330,322.00	101,910,000.27
335	Бусад авлага	71,266,105.03	40,174,800.00
3351	Байгууллагаас авах авлага	71,266,105.03	40,174,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,049,506,553.20	3,504,814,366.30
351	Түүхий эд материал	3,986,506,913.52	3,428,276,824.04
35110	Тусгай зориулалттай материал	3,674,812,144.85	2,419,064,802.20
35130	Эм боох материал	311,694,768.67	1,009,212,021.84
354	Хангамжийн материал	62,999,639.68	76,537,542.26
35410	Бичиг хэргийн материал	3,254,106.25	3,339,462.58
35420	Аж ахуйн материал	22,051,831.43	18,658,655.60
35430	Сэлбэг хэрэгсэл	11,528,550.00	22,571,422.67
35440	Түлш, шатах тослох материал	12,863,000.00	10,861,622.41
35450	Барилгын засварын материал	3,243,000.00	9,172,900.00
35460	Хүнсний материал	9,170,473.00	11,044,800.00
35470	Бусад хангамжийн материал	888,679.00	888,679.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	61,396,188,973.46	59,005,704,136.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	61,396,188,973.46	59,005,704,136.15
392	Биет хөрөнгө	55,253,888,741.96	52,888,922,938.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	34,431,907,452.00	35,946,090,307.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,188,433.99)	(1,331,028,734.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	389,966,980.00	414,935,021.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(331,965,165.21)	(358,265,835.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,118,875,312.71	39,181,252,910.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,715,271,061.13)	(22,219,051,339.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,043,334,192.27	3,460,252,322.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,023,232,794.69)	(2,466,822,956.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	568,544,247.56	568,544,247.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	(245,161,858.46)	(326,062,874.76)
39217	Ном	19,079,870.90	19,079,870.90
393	Биет бус хөрөнгө	6,142,300,231.50	6,116,781,198.10
39301	Програм хангамж	287,613,849.48	287,613,849.48
39302	Хуримтлагдсан элэгдэл	(245,792,517.98)	(271,311,551.38)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,100,478,900.00	6,100,478,900.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	65,729,407,503.69	62,663,166,742.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,584,031.00	8,700,852.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,584,031.00	8,700,852.00
413	Өглөг	7,584,031.00	8,700,852.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,823,031.00	437.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,761,000.00	8,601,115.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	99,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	65,721,823,472.69	62,654,465,890.70
51	Засгийн газрын хувь оролцоо	65,721,823,472.69	62,654,465,890.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,625,186,499.80	19,625,186,499.80
512	Хуримтлагдсан үр дүн	16,458,513,937.01	13,391,156,355.02
51210	Өмнөх үеийн үр дүн	19,572,252,680.84	16,458,513,937.01
51220	Тайлант үеийн үр дүн	(3,113,738,743.83)	(3,067,357,581.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,638,123,035.88	29,638,123,035.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	65,729,407,503.69	62,663,166,742.70

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	31,276,892,712.53	35,930,604,497.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,784,716,375.56	2,637,025,870.02
120	Нийтлэг татварын бус орлого	2,784,716,375.56	2,637,025,870.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	880,194,029.27	882,980,117.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	628,231,326.07	568,331,453.54
